



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/41

Дэлгэрхаан

Г Цэрэг татлага зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Батлан хамгаалах тухай хуулийн 17.1.4, аймгийн Засаг даргын 2018 оны А/121 тоот захирамж, аймгийн ЗДТГ-ын 2018 оны А/26 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны 1 дүгээр ээлжийн хугацаат цэргийн албаны татлагад 1992 оны 01 дүгээр сарын 01 ний өдрөөс 2000 оны 05 дугаар сарын 09 ний хооронд төрсөн 2 дугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэн залуучуудыг хамруулсугай.

2. Цэрэг татлага зохион байгуулах ажлын хэсгийн гишүүдийн үүргийг тодотгон цэрэг татах үйл ажиллагааг осол, зөрчилгүй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Холбогдох албан тушаалтан, мэргэжилтэнгүүдэд ДААЛГАХ нь:

а. “Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийг хамгаалах, боловсролын түвшинг дээшлүүлэх” хөтөлбөрийг хүрээнд 2 дугаар зэргийн цэргийн бэлтгэл үүрэгтэнг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах ажлыг 2018 оны 04 дүгээр сарын 26-наас 27-ний өдрүүдэд зохион байгуулахыг сумын ЭМТ-ийн дарга /М.Цэцэгээ/-д,

б. 18-25 насны 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн залуучууд нэг бүрт зарлан дуудах хуудас хүлээлгэн өгөх, холбогдох баримтыг бүрдүүлж цэрэг татлагын байранд заасан хугацаанд бэлэн байлгахыг багийн Засаг дарга /Ц.Болдбаатар, Г.Отгонпүрэв, Ж.Ганболд/ нарт

в. Цэргийн татлагын үеэр нийгмийн хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангуулж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллахыг сум, тосгоны хэсгийн төлөөлөгч /Э.Гэрэлт-Од, Б.Ганзориг/ нарт,

г. Хугацаат цэргийн албанд татагдагчдад хүргэх бичиг хэргийн болон тээвэр шатахуун, томилолтын зардлыг холбогдох зардлаас гарган зарцуулахыг сум, тосгоны Тамгын газар, захирагчийн ажлын албаны нягтлан бодогч /Э.Алтанхуяг, Г.Ганзориг/ нарт,

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, ажлын тайланг нэгтгэн фото зурагжуулж, баримтжуулан ажиллахыг сумын Төрийн захиргаа, хууль эрх зүйн мэргэжилтэн /Б.Гантуул/, тосгоны Дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн /Ө.Цогтбаяр/ нарт тус тус хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРБААТАР